

**СИБАРЁТАРО «ГАЙТО-О ЮКУ» ТОКИО, 1974. 389 о.
(Сибарётаро «Замаар одохуйд». Токио, 1974)**

Сүүлийн жилүүдэд Монголын түүх, соёл, улс төр, эдийн засгийн талаар дам буюу шууд холбоотой судалгаа бүтээлүүд Японд цөөнгүй хэвлэгдэж байна. Тийм бүтээлийн нэг нь 1973 онд манай оронд айлчилсан Японы зохиолч Сибарётарогийн хялбарчилсан цувралын «Замаар одохуйд» (Гайто-о юку) хэмээх тав дахь боть юм.

Сибарётаро Монгол нутгаар аялан явахдаа үзэж харсан, сонсож дуулсан зүйл мөн Монголын тухай гадаадын зохиол сэлтэд тулгуурлан бичсэн энэ номоо 1974 онд хэвлүүлжээ.

Монголын талаар зохиогч аль болох олон талын мэдлэг уншигчдаа өгөх зорилгоор Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүхийг эртнээс эдүгээ хүртэл хамруулахын зэрэгцээ монголчуудын соёл, зан үйл зэрэг тал бүрийг багтаах гэж оролдсон нь илэрхий байна. Энэ нь тийм ч хялбар биш нь мэдээж. Гэвч Сибарётарогийн номыг уншихад манай түүхэн хөгжлийн замнал, түүний онцлогийн талаар нилээд онож хэлсэн газар нэг биш тааралдаж байна. Ялангуяа ардын хувьсгалын жилүүдэд олсон манай ард түмний ололт амжилтыг зохиогч Октябрийн социалист хувьсгалын үр нөлөөтэй холбож үзээд: «Монголын нийслэл их Хүрээ 1921 оны байдлаар хятадын худалдаачид, мөнгө хүүлэгчдийн хамгийн их ашиг олж байсан ичээ үүр байв. Оросод хувьсгал (Октябрийн) гарсан нь дэлхийн дарлагдсан ард түмэн тухайлбал Монгол оронд ихээхэн нөлөө ач холбогдол үзүүлэв. Хэрэв энэ хувьсгал арван жилийн дараа гарсан бол Ар Монголын ард түмэн хуучин Хятад буюу хаант Орос улсын аль нэгэнд нь уусан автагдсан ч байж магадгүй» (144-р тал) гэжээ. Тэр цааш нь Монгол оронд «хагас зуун жилийн өмнө» мандсан хувьсгалын үр дүнг дүгнэж «Нүүдэлчин улс социалист нийгэмд дэвшин орсон нь хүн төрөлхтний түүхэнд гарсан анхны эрхэм чухал туршлага» (12-р тал) гэж цохон тэмдэглэжээ.

Монголын түүх, соёлын зарим онцлогийн талаар бичихдээ зохиогч «Монголчууд эрт дээр үеэс Хятадын соёл иргэншлийг огт хүлээн аваагүй, тэр ч байтугай удам дамжин овог зүүхийг дууриагаагүй, хувцас зан заншлаа өөрчлөөгүй, хэл зүйн талд ганц нэг эзэлж авсан үг байгаа хирнээ тэр нь тун цөөн. Юан гүрнээс (1280-1367 он) хойш ч дулаан уур амьсгалтай Хятад газраас Умард нутагтаа буцсан нь үнэхээр сонин ажээ» (132-р тал) гэж

сүрхий гярхай тэмдэглэжээ. Гэвч Сибарётарогийн номыг алдаа мадаг огт үгүй гэхэд учир дутагдалтай юм. Үүнтэй холбогдуулж уг номоос ганц нэг жишээг иш татая. Тухайлбал, «Манж Чин улсын (1636-1912 он) үед хятадын худалдаачид монголчуудыг худалдаа хийх ямар ч мэдлэггүй хэмээн мөлжиж, аажмаар тэднийг бүр хоослов» (141-142-р тал; түүнээс болж, тус орны эдийн засгийн үндэс нүүдлийн мал аж ахуй бууран доройтлоо гэсэн атлаа монголын ард түмэн манжийн түрэмгийлэгчдийг эсэргүүцэн олон жилийн турш шаргуу тэмцэл явуулж байсныг зохиогч тойрон өнгөрчээ.

Монголын түүхийг хүннүгийн үеэс эхлэн цухас дурдахыг хуссэн зохиогч хятадын «Умард Хан улсын судар» (Гокансё)-т «Тэд (хүннү нар) ус, өвс даган малаа хариулна, тогтсон газаргүй, овоохойгоор гэр орноо хийж, мах идэж, айраг уун амьдарна» гэсэн өгүүлбэрийг иш татаад монголчуудын аж төрөх ёс «одоо хүртэл өөрчлөгдсөнгүй тэр хэвээрээ байгаа» (130-р тал) мэтээр бичсэн нь манай орны ололт амжилтыг нүдээр үзэж үнэлсэн зохиогчийн өөрийн нь зарим бодит дүгнэлттэй сүрхий зөрчилджээ.

Хувьсгалаас хойших жилүүдэд нам засгаас авсан асар их арга хэмжээний үр дүнд манай орны социалист хөдөө аж ахуй байнга хөгжиж, нэгдэлчдийн материаллаг аж байдал, соёлын хэмжээ асар их дээшилж «Хан улсын үеийнхтэй» хавьтах юмгүй болсон нь шөнө өдөр шиг ялгаагай билээ.

Зохиогч Монголын тухай өгүүлэхийн зэрэгцээ Монгол-Хятад, Монгол-Японы харилцааг зарим талаар хөндсөн байна. Монгол-Хятадын харилцааны тухай зохиогч «хэдэн мянган жилийн турш Монголын нүүдэлчин улс өмнө зүгт тархсан тариачин Хятад улстай холбоотой байв. Нэг үе зөрөлдөж, нөгөө үе худалдаа хийж, сүүл сүүлдээ уг холбоо нь, мөн хүмүүсийн харилцаа нь суларч ирсэн. Азийн түүх бол морь унасан малчин тариачин улсын хоорондын тэмцлийн түүх байсан» (138-р тал) гэж тодорхойлоод, тэмцлийн шалтгааныг зохиогч юуны өмнө «хоёр ард түмний аж ахуй эрхлэх хэлбэр, түүний ялгаанд оршино» гэж үзсэн байна. (139-р тал)

Япон-Монголын харилцааны талаар бичихдээ: «Монгол орны хувьд бол XX зууны эхний хагаст хамгийн хорт дайсан нь Япон байсан (190-р тал) уг харилцаа «одоо намжмал байдалтай байна» гэх мэтээр өгүүлсэн нь 1921 онд эрх чөлөө тусгаар тогтнолоо байлдан олсон

цагаас хойш аливаа ард түмэн, түүний дотор Японы ард түмний хувьд жинхэнэ энх тайвныг

ард түмэн, түүний засгийн газрын бодлогыг Сибарётарогийн номноос уншигч чухам юу гэж ойлгох нь тодорхойгүй байна.

Зохиогч номдоо манай орны түүх, шинэ нийгмийн амьдралын зарим асуудлаар тийнхүү өнгөц дүгнэлт хийсэн газар цөөнгүй нь харам-

эрхэмлэж ирсэн ба одоо ч эрхэмлэсээр буй монголын

салтай. Гэвч Сибарётарогийн ном япончууд болон япон хэл мэддэг хүмүүст Монгол орны талаар зохих хэмжээний анхны мэдэгдэхүүн өгөх нь лавтай буй заа.

О. Оюунгэрэл.

GABRIEL CALAFORRA. “RUPUBLIKA POPULAR DE MONGOLIA” LA HABANA, 1980, 107 pag

(Габриель Калафорра. «Бүгд Найрамдах Монгол Ард Улс» Гавана хот. 1980, 107 хууд)

Бүгд Найрамдах Куба улсын нэр хүндтэй томоохон хэвлэлийн газар болох «Пуэбло» (Ард түмэн) хэвлэлийн газрын «Залуу үе» гэдэг салбараас эрхлэн «Бүгд Найрамдах Монгол Ард Улс» гэдэг нэртэй улс төр, эдийн засгийн лавлахыг испани хэлнээ саяхан хэвлэн гаргалаа.

Уг номонд монголын ард түмэн ардын засгийн жилүүдэд социалист байгуулалтын бүхий л салбарт олсон ололт амжилтын тухай тоо баримтыг статистикийн албан ёсны баримтад тулгуурлан оруулжээ. Кубын өргөн олон уншигч нарт зориулан БНМАУ-ын төрийн туг, далбаа, сүлд, соёмбын утга учир болон монгол түмний зан заншил, зочломтгой байдал түүнчилэн үндэсний хоол, ундааны талаар дэлгэрэнгүй материал нийтэлсэн байна.

Монголын ард түмний соёл урлагийн амьдралд гарсан дэвшилт өөрчлөлт, хэл уран зохиолын талаар танилцуулан бичихдээ Д. Нацагдоржийн болон бусад нэрт зохиолч, яруу найрагчдын бүтээлээс тухайлбал, их ууган яруу найраг-

чийн «Миний нутаг» шүлгийг испани хэлнээ бүрэн дүүрэн нийтэлсэн явдал уг номыг улам яруу сайхан сонирхолтой болоход чухал үүрэг гүйцэтгэжээ.

Мөн энэхүү номонд Монголын газрын зураг болон өнөөгийн социалист Монголын нийгэм эдийн засаг, хүн ардын тухай олон гэрэл зураг хавсаргасан байна. Номыг зохиогч Габриель Калафорра нь олон улсын хууль зүйн мэргэжилтэй боловч Монгол орны түүх, хэл зохиолыг өнгөцхөн сонирхогч бус харин ч энэ талаар нилээд ном зохиол уншин судалсан гүн гүнзгий мэдлэгтэй болохоо харууллаа.

Ийнхүү өнөөгийн социалист Монголын тухай шинэ ном ах дүү Кубын уншигч олонд очиж байгаа явдал бол зөвхөн Куба төдийгүй испани хэлээр хэлэлцэх Латин Америкийн бусад ард түмний хүртээл болж, монгол-латин америкийн ард түмний найрамдал, хамтын ажиллагааны ариун үйлсэд бас нэгэн чухал хувь нэмэр болох нь эргэлзээгүй.

Б. Батболд.